



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 11

Мөрөн

Үндсэн хөрөнгө актлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөрөн сумын 5 дугаар цэцэрлэгийн эзэмшилд байгаа 1965 онд ашиглалтад орсон 27,661,510 төгрөгийн анхны өртөгтэй, 24,588,008.9 төгрөгийн үлдэх өртөгтэй салбар бүлгийн барилга нь Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2020 оны 23.07.028/6 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон тул тус хөрөнгийг актлахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д зөвшөөрсүгэй.

2. Актлагдсан барилгыг данснаас хасахыг Мөрөн сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийг түр орлон гүйцэтгэгч (Д.Даваажав)-д, барилгын талбайг чөлөөлж, стандартын шаардлага хангасан барилга барих ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга (Л.Ганболд)-д даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

119120031